

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 12-р сарын 26-ны байдлаар


2018 оны 12-р сарын 26-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 3.0 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.4 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 12-р сарын 26-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 2.9, үхрийн ястай махны үнэ 6.5 хувь, үхрийн цул махны үнэ 10.2 хувь, ямааны ястай махны үнэ 10.6 хувь, адууны ястай махны үнэ 11.2 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 2.0 хувь, үхрийн ястай махны үнэ 0.9 хувь, үхрийн цул махны үнэ 0.2 хувиар өссөн бол ямаа болон адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

2018 оны 12-р сарын 26-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6885 төгрөг, үхрийн /ястай/ мах 8520 төгрөг, үхрийн цул мах 10300 төгрөг, адууны /ястай/ мах 6525 төгрөг, ямааны /ястай/ мах 5500 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг



Гурилын үнэ: 2018 оны 12-р сарын 26-ны гурилын үнэ өмнөх сар болон өмнөх сараас бүх гурилын үнэ 0.4-5.5 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос дээдийн дээд савласан гурилын үнэ 1.1 хувиар өссөн байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 12-р сарын 26-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 7.9 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 0.2 хувиар буурсан бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 12-р сарын 26-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 4.5 хувь, луувангийн үнэ 1.8 хувь, байцааны үнэ 7.1 хувь, хүрэн манжингийн үнэ 2.5 хувь, сонгины үнэ 0.6 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 12-р сарын 26-ны байдлаар задгай сүүний үнэ 18.6 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ өмнөх сараас 2.3 хувиар өссөн бол элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.4 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос задгай сүүний үнэ 18.8 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй харин цөцгийн тосны үнэ өмнөх сараас 1.2 хувиар өссөн бол өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. Өндөгний үнэ өмнөх сараас 11.5 хувиар өссөн, өмнөх 7 хонгоос өөрчлөлтгүй байна.